

**“Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 29-ны өдрийн
Ээлжит хурлын тэмдэглэл:**

2025 оны 04 сарын 29 өдөр

№01

Улаанбаатар хот

Хаана: Хэнтий аймаг, Батноров сум, “Бэрх Уул” ХК-ийн төв оффисын байр

Эхэлсэн цаг: 09:00 цагт

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Баярцэнгэл, хурлын нарийн бичгийн дарга О.Мөнхгэрэл, тооллогын комиссын дарга Д.Уянга, тооллогын комиссын гишүүн Л.Тэмүүжин, Э.Ууганцэцэг нар, 4 хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцов.

Тооллогын комиссын дарга Д.Уянга “Бэрх Уул” ХК-ийн 2025 оны 04 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцууллаа. Нийт 19’062’080 ширхэг хувьцаанаас нийтдээ 99.66% буюу 18’997’615.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өөрийн биеэр оролцож хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдэж байна.

Хурлын ирц: 99.66 хувь

Хурлын дарга А.Даваажав: Хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн мэнд хүргье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- Хурлын завсарлага
- Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- Хурлыг хаах

Хурлын дарга компанийн гүйцэтгэх захирал А.Даваажав хуралд оролцогч талуудтай мэндчилж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах

2. 2025 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах
3. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох
5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
6. Зээл, өр төлбөрийн талар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах

Хурлын дарга А.Даваажав: 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Хурлын дарга А.Даваажав Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцүүлэв.

“Бэрх Уул” ХК нь Чандган тал MV-04590А талбайгаас нүүрс олборлон дотоодод буюу Хэнтий аймаг, сумдын хэрэглэгчдийг халаалтын улиралд нүүрсээр ханган ажиллаж байна.

Компанийн 2024 оны жилийн орлогын тайлан нь дараах байдалтай байна. /Мянган төгрөг/

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2023 он	2024 он
Борлуулалт	мян. төг	1,940,729.7	1,134,182.53
ББӨ	мян. төг	1,426,182.0	1,018,339.31
Нийт ашиг (алдагдал)	мян. төг	514,547.7	115,843.22
Бусад орлого	мян. төг	167,690.9	108,106.17
Ерөнхий удирдлагын зардал	мян. төг	864,341.7	921,342.89
Санхүүгийн зардал	мян. төг	216,519.9	0.0
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	мян. төг	1,353,102.7	(697,393.49)
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	мян. төг	0.0	0.0
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	мян. төг	0.0	0.0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	мян. төг	1,401,563.3	(697,393.49)
Орлогын татварын зардал	мян. төг	48,460.6	0.0
Татварын дараах ашиг (алдагдал)	мян. төг	1,353,102.7	(697,393.49)

Санхүү байдлын тайлан 2024 (Мянган төгрөг)

№	Хураангуй баланс	2023 он	2024 он
1	ХӨРӨНГӨ:		
2	Эргэлтийн хөрөнгө	1,306,746.30	1,148,526.68
3	Эргэлтийн бус хөрөнгө	6,308,773.5	6,404,724.79
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,615,519.84	7,553,251.47
5	ӨР ТӨЛБӨР:		
6	Богино хугацаат өр төлбөр	27,164,854.72	27,791,455.88
7	Урт хугацаат өр төлбөр	8,098,717.5	8,107,246.38
8	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:	35,263,572.24	35,898,702.27
9	ЭЗДИЙН ӨМЧ		
10	Хувийн өмч	1,906,208.00	1,906,208.00
11	Дахин үнэлгээний нэмэгдэл	1,990,685.16	1,990,685.16
12	Хуримтлагдсан ашиг	-31,544,945.56	-32,242,343.96
13	ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН	-27,648,052.40	-28,345,450.79
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,615,519.84	7,553,251.47

Компани нь санхүүгийн тайлан баланс, болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар, агаарын бохирдлын албан татвар мөн нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь тогтмол гаргаж тайлагнадаг.

Чандганы хэсэг

ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Чандган талын хүрэн нүүрсний орд нь Нялгын нүүрсний сав газрын зүүн хойд хэсэгт Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Шорвогийн тал хэмээх газарт оршдог. Улаанбаатар хотоос 290км-т зүүн чиглэлийн мянганы замаас урагш 5км Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос баруун хойш 54 км зайд байрладаг.

Тус орд нь дэд бүтцийн хувьд зам харилцаа, цахилгаан холбоо хөгжсөн, хүн ам суурьшсан төв суурин газруудтай ойрхон, эдийн засгийн харьцангуй тааламжтай

нөхцөлд оршдог. Газрын гадаргуугын усан сүлжээний хувьд байнгын урсгал ус байхгүй, тогтмол нуур, цөөрөмтэй. Энд тогтсон нуурууд нь хур тунадасны усаар тэжээгддэг давстай нуурууд байдаг. Орд нь зүүн хойноос баруун урагш сунасан 1400-1500м өндөртэй уул нуруугаар хязгаарлагдсан уулс хоорондын далайн түвшнээс 1150-1188м-т өргөгдсөн хөндийд байрлана. Газрын гадаргын хувьд жижиг дов, толгод зонхилсон хотгор, гүдгэртэй тал хээрийн бүсийн шинжтэй гадаргуутай. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь харьцангуй дулаахан, 15-35 хэм хүртэл халах ба бороо хурын үед сэрүүвтэр байна. Өвөл нь 25-37 хэм хүйтэн, эхний цас 10-р сарын эхээр орно. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 350мм бөгөөд үүний ихэнх нь 6-8 дугаар сарын хооронд ордог. Салхины чиглэл голлон зүүн хойноос баруун урагш чиглэлтэй 20 м.с хүртэл хурдтай байна. Орон нутгийн хүн ам ихэнхи нь мал аж ахуй болон газар тариалан эрхлэн үр тариа, хүнсний ногоо тарьж орон нутгийн хэрэгцээг хангана.

Чандганы нүүрсний уурхайг ЗГ-ийн 1999 оны 05-р сарын 02-ны өдрийн 74 тоот тогттолын дагуу “Бэрх Уул” ХК-ийн бүрэлдэхүүнд нэгтгэсэнээс хойш өнөөдрийг хүртэл хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг явуулж Хэнтий аймгийн төв болон зарим сумдыг нүүрсээр ханган тасралтгүй ажиллаж ирсэн.

Тус уурхайн олборлолтын хэмжээ нь Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчийн жилийн хэрэгцээнээс шууд хамааралтай.

Чандганы хэсгийн 2024 оны борлуулалт үйл ажиллагаа

Чандганы нүүрсний уурхай нь орон нутгийн чанартай нүүрсний уурхай тул дотоодод буюу Хэнтий аймгийн төвийн болон бусад сумдын аж ахуй нэгж, хувь хүмүүст жилийн 1-4, 10-12-р саруудад нүүрс олборлон борлуулдаг.

2024 онд төвлөрсөн халаалтын зуухнууд болон үйлдвэр аж ахуйн газарт 30.7 мянган.тн нүүрсийг олборлон борлуулж, нийт 1,134,182 төгрөгийн орлого олсон.

№	Төрөл	Хэмжих нэгж	2023	2024
1	Нүүрсний борлуулалт тн	тн	57,228	30,700
2	Нүүрсний борлуулалт /төг/	сая.төг	1,940,729	1,134,182

Хийгдсэн ажлууд:

“Бэрх Уул” ХК-ийн Чандганы нүүрсний уурхайн хэсэг нь 6кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, 400кВА чадалтай КТПН маягийн дэд өртөө барьж ашиглалтанд оруулж уурхайн эргэн тойрны бүрэн камержуулж зайнаас хянах боломжтой болсон мөн уурхай ус шүүрүүлэлтийн ажлын 2024 оны 11 сараас эхлүүлсэн. Үүний үр дүнд 2023 оны жилийн нийт хөрс хуулалтын хэмжээ 175.0 мянган метр куб байсан бол 2024 онд 5.9 мянган метр куб хөрс хуулалт хийгдсэн.

Техник тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ

Тус уурхай нь дараах техникүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- KOMATSU-D155A, KOMATSU -D65A /Бульдозерууд/
- DOOSAN эксковатор, /300.500/
- ZL50C-автоачигч 2 ширхэг
- Ланд Крусер 78-1 ширхэг
- Запрушка-1 ширхэг
- Автосамасвол-2 ширхэг

Зэрэг техникүүдээр 2024 онд уурхайн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Автоачигч, бульдозер, экскеватор зэрэг техникүүдийн ашиглалтын хугацаа дууссан, явах эд анги болон бусад эд анги муудсан зэргээс шалтгаалан техник эвдэрч байсан бөгөөд дараах засвар үйлчилгээг хийсэн

Техник тус бүр дээр дараах зардлууд гарсан байна.

Уурхайн дэд бүтэц, тохижилт, туслах аж ахуйн хүрээнд

- 08 сард Бэрх хотын хогийн цэгийг хашаажуулж, хур хог хагдлыг түрж булах ажлыг хийж гүйцэтгэсэн
- Чандганы уурхайн дэргэдэх оффисын дотор өрөөний хуваарилалт, бүтцийг өөрчилж засвар хийж тохижуулав.
- Чандгана оффисын дотор хөнгөнөөр бие засах ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө гаргаж тохижуулав
- Чандганы уурхайн карьер руу 380 вольтын цахилгаан татав.
- Чандганад цооног өрөмдөв.
- Чандганы объектуудын харуул хамгаалалтыг сайжруулж, камержуулалтыг сайжруулав.
- Чандганы уурхайн дэргэдэх оффисд шинээр ХХАБ-ын өрөө байгуулан тохижуулав.

- Ажилчдын хоол хүнсэнд төмс, лууван, сонгино тарьсан
- Ажилчдын биеийн онцлогт нийцсэн хувцас захиалгаар хийлгэж иж бүрэн ажлын хувцас өмсгөл, гутлаар хангав.

Чандганы уурхайн ажилчдыг хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцсаар хангаж, хор саармагжуулах сүү, аарц, чацарганы шүүсийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэж байна.

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөн, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

Хүний нөөц, боловсон хүчин

2024 онд тус компани нь Захиргааны хэсэгт-8 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-14 ажилчин, Харуулын албаны хэсэгт-7 ажилчин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, нийт 29 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Үүнээс эмэгтэй-10, эрэгтэй-25 ажилчидтай.

Тус онд ажилчдаасаа мэргэжлийн гагнуурчин, компанийн засаглал зэрэг сургалтанд хамруулсан.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэчилдэг. Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж ирлээ.

2024 оны онцлох үйл явдлууд:

- Монголын уул уурхайн салбарын 100-н жилийн ойг тохиолдуулан хийгдэж буй далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв буюу Бэрхийн далд уурхайн музейн ажилд зориулан “Бэрх-Уул” ХК-ийн нэрэмжит танхим өрөөг тохижуулах ажил хийгдэж хүлээлгэн өгсөн.
- Бэрх Уул” ХК-ийн төв оффисын урд талбай, хүндэтгэлийн гэрийн урт хэсэгт чулуу суулган засаж, хашааны үүд хэсгийг чулуугаар хийж орох гарцыг өөрчлөв.
- Чандганы хэсэгт ажилчидын хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг хангасан

- Малын тэжээлд царгас, ажилчдын амжиргаанд чацарганы мод тариж нутагшуулж байгаа
- Чандганы хэсгийн ажилчдын байр, гал тогооны зөөврийн усны асуудлыг бүрэн шийдсэн

Нийгмийн хариуцлагын хүрээнд

- Бэрх Уул” ХК-ын ажилчид байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцож, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Мөрөн сумын Чандгана багт байрлах Чандганы уурхайд 1 га газарт царгас тарьяла.
 - Үндэсний сурын харвааны нээлттэй тэмцээнийг “Бэрх уул” ХК-ийн нэрэмжит болгон ивээн тэтгэж, цаашид уламжлал болгон зохион байгуулахаар боллоо.
- “Бэрх Уул” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсэн талаар танилцууллаа.

- Гүйцэтгэх захирал А.Даваажав 2025 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон орлого зардлын төлөвлөгөөг танилцуулав.

" БЭРХ УУЛ " ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төрөл	Хэмжих нэгж	2024 төсөв	2025 төсөв
			Төсөв	Төсөв
1	Бүтээгдэхүүн олборлолт			
1	Нүүрс	тн	57,100	49,190
2	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	2,113,700	2,213,550
1	Нүүрс	мян.төг	2,112,700	2,213,550
2	Нүүрс тээврийн орлого	мян.төг	1,000	0
3	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - нийт	мян.төг	1,150,812	1,425,409
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	285,000	295,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	41,325	42,775
3	Албан томилолтын зардал	мян.төг		1,000
4	Хүнсний зардал	мян.төг	30,000	30,000
5	ХХААжиллагааны зардал	мян.төг	11,000	10,000
6	Шатахуун тосны зардал	мян.төг	410,000	350,000
7	Техникийн түрээсийн зардал	мян.төг	35,000	35,000
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	58,000	40,000
9	Сэлбэг материал	мян.төг	90,000	90,000
10	Байрны урсгал засвар	мян.төг	35,000	35,000
11	Цахилгаан	мян.төг	35,000	300,000
12	Лицензийн төлбөр /4590 А /	мян.төг	320	0
13	АМНАТөлбөр	мян.төг		55,339
14	Зээлийн хүүгийн зардал		52,817	55,000
15	Газрын төлбөр	мян.төг	2,100	2,700
16	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	мян.төг	28,550	24,595

17	Геологи,судалгааны ажлын зардал	мян.төг	15,000	15,000
18	Нөхөн сэргээлийн зардал			5,000
19	Тээврийн зардал			
20	Бичиг хэргийн зардал	мян.төг	2,000	1,000
21	Шуудан холбооны зардал	мян.төг	3,000	3,000
22	Хангамжийн материалын зардал	мян.төг	1,000	2,000
23	Хог хаягдлын төлбөр	мян.төг	4,700	3,000
24	Ногоо, тэжээл тарих	мян.төг	6,000	
25	Бусад зардал	мян.төг	5,000	30,000

№	Ашиг алдагдал -нийт	хэмжих нэгж	2024 төсөв	2025 төсөв
			Төсөв	Төсөв
1	Борлуулалт	мян.төг	2,112,700	2,213,550
2	ББӨ	мян.төг	1,150,812	1,425,409
3	Нийт ашиг	мян.төг	961,888	788,141

ЗАХИРГАА АЖ АХУЙН ХЭСГИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2024 он	2025 он
			Төсөв	Төсөв
1	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	260,950	210,950
1	Бусад орлого	мян.төг	250,000	200,000
2	Түрээсийн орлого	мян.төг	10,950	10,950
	Нийт зардлын дүн	мян.төг	806,627	648,185
1	Цалингийн зардал	мян.төг	360,000	290,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	50,400	40,600
3	Түрээсийн зардал	мян.төг		50,000
4	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	5,000	5,000
5	Элэгдлийн зардал	мян.төг	72,000	72,000
6	Шатахуун тос	мян.төг	65,000	25,000
7	Бичиг хэргийн зардал	мян.төг	3,500	2,500
8	Шуудан холбоо	мян.төг	3,000	3,000
9	Программ хангамж	мян.төг	1,522	2,000
10	Сэлбэг хэрэгслийн зардал	мян.төг	20,000	20,000
11	Байрны урсгал засвар	мян.төг	35,000	50,000
12	Цахилгааны зардал	мян.төг	3,500	2,000
13	Халаалт дулааны зардал	мян.төг	55,000	15,000
14	Лицензийн төлбөр / 10965A /	мян.төг	842	842
15	Лицензтэй холбоотой бусад	мян.төг		
16	АТБӨЯХАТатвар	мян.төг		
17	Бууны татвар	мян.төг	120	120
18	ҮХХАТатвар	мян.төг		9,000
19	Газрын төлбөр	мян.төг	323	323

20	Геологи хайгуул судалгааны ажлын зардал	мян.төг		
21	Аудит, үнэлгээний зардал	мян.төг	10,000	10,000
22	Хуулийн зөвлөх үйлчилгээ	мян.төг		
23	МХБиржийн бүртгэлийн хураамж	мян.төг	1,800	1,800
24	Бусад/буцалтгүй тусламж/	мян.төг	2,000	3,000
25	Банкны шимтгэл	мян.төг	1,000	1,000
26	Хог хаягдлын төлбөр	мян.төг	120	
27	Хангамжийн материал	мян.төг	1,500	
28	Ажилчдын сургалтын зардал	мян.төг		
29	Хандив, Спортын арга хэмжээ, Еслол хүндэтгэлийн арга хэмжээ	мян.төг	55,000	25,000
30	Бусад зардал	мян.төг	60,000	20,000

ТУЗ-н 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2024 он	2025 он
			Төсөв	Төсөв
1	ТУЗ-н даргын цалин	мян.төг		
2	ТУЗ-н даргын түлшний зардал		7,500	2,500
3	ТУЗ-н гишүүдийн цалин	мян.төг		
4	ТУЗ-н нарийн бичгийн цалин	мян.төг		
5	Хурлын материал орчуулгын зардал	мян.төг	300	300
6	ТУЗ-н бичиг хэргийн зардал	мян.төг	100	100
7	ТУЗ-н даргын томилолтын зардал	мян.төг		
8	ТУЗ-н хурлын зардал	мян.төг	250	250
9	ТУЗ-н НДШимтгэл	мян.төг		
10	Удирдлагын бусад /Утас, сэлбэг, бусад/	мян.төг	6,960	1,000
Нийт зардлын дүн		мян.төг	15,110	4,150

ЧАНДГАНЫ ХЭСГИЙН 2025 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2024 он	2025 он
			Төсөв	Төсөв
1	Бүтээгдэхүүн олборлолт			
1	Нүүрс	тн	57,100.00	49,190
2	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	2,112,700	2,213,550
1	Нүүрс	мян.төг	2,112,700	2,213,550
3	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - нийт	мян.төг	1,150,812	1,425,409
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	285,000	295,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	41,325	42,775

3	Албан томилолтын зардал	мян.төг		1,000
4	Хүнсний зардал	мян.төг	30,000	30,000
5	ХХААжиллагааны зардал	мян.төг	11,000	10,000
6	Шатахуун тосны зардал	мян.төг	410,000	350,000
7	Техникийн түрээсийн зардал	мян.төг	35,000	35,000
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	58,000	40,000
9	Сэлбэг материал	мян.төг	90,000	90,000
10	Байрны урсгал засвар	мян.төг	35,000	35,000
11	Цахилгаан	мян.төг	35,000	300,000
12	Лицензийн төлбөр /4590 А /	мян.төг	320	
13	АМНАТөлбөр	мян.төг		55,339
14	Зээлийн хүүгийн зардал		52,817	55,000
15	Газрын төлбөр	мян.төг	2,100	2,700
16	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	мян.төг	28,550	24,595
17	Геологи,судалгааны ажлын зардал	мян.төг	15,000	15,000
18	Нөхөн сэргээлийн зардал			5,000
19	Тээврийн зардал			
20	Бичиг хэргийн зардал	мян.төг	2,000	1,000
21	Шуудан холбооны зардал	мян.төг	3,000	3,000
22	Хангамжийн материалын зардал	мян.төг	1,000	2,000
23	Хог хаягдлын төлбөр	мян.төг	4,700	3,000
24	Ногоо, тэжээл тарих	мян.төг	6,000	
25	Бусад зардал	мян.төг	5,000	30,000

3. Компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг сунгаж

1. Ердийн гишүүнд:

- Раднаагийн Бадрах
- Амарсайханы Даваажав
- Бадрахын Наранзаяа
- Бат-Очирын Аригуун
- Батжаргалын Баярцэнгэл
- Өлзийбүрэнгийн Алдарбаяр нарыг

Хараат бус гишүүнд:

- Ёндонгийн Амарбат
- Дансрангийн Энхболд
- Лувсанчүлтэмийн Тэмүүжин нарыг хэлэлцүүлэн шийдвэрлэв.

4. Компани 2024 оны санхүүгийн тайлантай танилцаж хувь нийлүүлэгчдэд 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ-ийн шийдвэрлэснийг танилцуулж батлав.

5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээтэй холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулж хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.
6. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлж шийдвэрлэв.


Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Д.Уянга хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулав.


1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. 2025 оны ажлын төлөвлөгөөг, зардлын төсвийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
4. Компанийн шинэ ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдээс Р.Бадрах 16.7%, Б.Наранзаяа 16.7%, А.Даваажав 16.7%, Б.Аригуун 16.7%, Б.Баярцэнгэл 16.7%, Ө.Алдарбаяр 16.7%, тус тус саналтайгаар ердийн гишүүнээр сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд Л.Тэмүүжин 33.3%, Ё.Амарбат 33.3%, Д.Энхболд 33.3% саналтайгаар тус тус хараат бус гишүүдээр сонгогдлоо.

5. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
6. Зээл, өр төлбөрийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.

Хурал: 11:50 өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хянасан хурлын дарга:  /А.Даваажав/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  /О.Мөнхгэрэл/

2025 оны 04 сарын 29-ны өдөр

Улаанбаатар хот